

БАТЛАВ:
ОРОН НУТГИЙНӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА

Н.ГАНБОЛД

БАТЛАВ:
“.....” ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГЫН
ТЭРГҮҮН

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2020 оны ... дугаар
сарын ... өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү “Хамтран ажиллах гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ыг тус тус үндэслэн:

Нэг талаас: Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба (цаашид “Төрийн байгууллага” гэх), түүнийг төлөөлж худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Эрдэнэсүрэн

Нөгөө талаас: “.....” ТББ (цаашид “Төрийн бус байгууллага”, хамтад нь “Талууд” гэх), түүнийг төлөөлж Тэргүүн нар нь энэхүү гэрээнд заасан нөхцөлийн хүрээнд харилцан тохиролцож 20.. оны 02 дугаар сарын ... -ний өдөр байгуулав.

Хоёр. Гэрээний зорилго, гол нөхцөл

2.1 Төрийн байгууллага нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын мөн харьяа төсвийн байгууллагын худалдан авах ажиллагааг ил тод, шударга, хуулийн хүрээнд зохион байгуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо (цаашид “Үнэлгээний хороо” гэх)-д салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаас мэргэжлийн, хараат бус 2 (хоёр)-оос доошгүй хөндлөнгийн хяналт тавих үүрэг бүхий гишүүнийг ажиллуулах, үнэлгээний хороонд ажилласан гишүүдэд холбогдох журмын дагуу урамшуулал олгох, Төрийн бус байгууллага нь худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан, худалдан авах ажиллагааны чиглэлээр мэдлэгтэй, үнэлгээний хороонд хараат бус, шударга, хуулийн дагуу ажиллах боломжтой гишүүнийг төрийн байгууллагад санал болгох, санал болгосон гишүүдэд худалдан авах ажиллагааны талаар мэргэжил, арга зүйн туслалцаа олгох, түүнтэй холбогдон үүсэх эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

2.2 Талууд харилцан тохиролцож дараах нөхцөлийг гэрээний гол нөхцөл болгон хүлээн зөвшөөрсөн болно;

2.2.1 Төрийн байгууллага нь үнэлгээний хороонд ажиллах мэдлэг, чадвар, шаардлага бүхий мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаас санал болгосон гишүүдийг өөрийн болон харьяа байгууллагад санал болгож, ажиллуулна;

2.2.2 Төрийн бус байгууллагын санал болгох гишүүд нь заавал тухайн мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын чиглэл, салбарын худалдан авах ажиллагаанд оролцохгүй бөгөөд бусад салбарын худалдан авах ажиллагаанд оролцно.

2.2.3 Төрийн бус байгууллагын санал болгох гишүүн нь төрийн байгууллагаас зарласан худалдан авах ажиллагааны үнэгээний хороонд тухайн салбарын мэргэжилтний хувиар бус худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, журам, зааврын дагуу зохион байгуулахад хамтран ажиллана;

2.2.4 Төрийн бус байгууллагын гишүүд нь худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын хүрээнд, хөндлөнгийн нөлөөнд автахгүй, хараат бус, ил тод явуулж буй эсэхэд хяналт тавих бөгөөд үнэлгээний хорооны хуралд саналын адил эрхтэй оролцоно;

2.2.5 Төрийн бус байгууллагын гишүүн нь худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдаж, АЗ гэрчилгээ авсан байна.

2.2.6 Төрийн бус байгууллага нь энэхүү гэрээний хүрээнд худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажиллах гишүүнд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага, эрх зүйн үр дагаврыг сайтар танилцуулж, гэрээний нэг хувийг хадгалуулна;

2.2.7 Төрийн байгууллага нь үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан төрийн бус байгууллагын гишүүний урамшууллыг Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар батлагдсан Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам-аар зохицуулж урамшуулал олгоно. Урамшууллыг түүний хувийн дансанд жилийн эцэст нэг удаа нэгдсэн дүнгээр шилжүүлнэ;

2.3 Талууд хамтын ажиллагаанд ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, өрсөлдөх тэгш боломжтой, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөндлөнгийн нөлөөнд үл автах, үнэлгээний хороонд хөндлөнгийн хяналт тавих зарчмыг баримтална.

2.4 Дараах баримт бичиг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна;

2.4.1 Төрийн буй байгууллагын гишүүний үнэмлэх, нотлох баримт бичиг;

2.4.2 Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдсан АЗ сертификат;

2.4.3 Төрийн бус байгууллагын төлөөлөгчийн анкет.

Гурав. Гэрээний хугацаа, урамшуулал

3.1 Энэхүү гэрээ нь 2019 оны 01 дүгээр сарын ...-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын-ны өдрийг хүртэл мөрдөгдөнө.

3.2 Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүнд олгох урамшуулал нь 1 тендер шалгаруулалтад 20,000 (хорин мянган) төгрөг байна. Тендер шалгаруулалт нь үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсоноос эхлээд захиалагчид зөвлөмж дүгнэлт олгох хүртэлх үйл явцыг хамаарна.

Дөрөв. Төрийн байгууллагын эрх, үүрэг

4.1 Төрийн байгууллага нь өөрийн болон харьяа салбар, хүрээний байгууллагын худалдан авах ажиллагааг ил тод, шударга, хуулийн хүрээнд зохион байгуулах боломжийг хангах зорилгоор худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гишүүнийг санал болгохыг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаас шаардах эрхтэй.

4.2 Төрийн бус байгууллагаас ирүүлсэн худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээтэй гишүүдийг нэгдсэн жагсаалтад бүртгэж, төсөл, арга хэмжээг худалдан авах үнэлгээний хороонд санамсаргүй байдлаар сонгож, ажиллуулах үүрэгтэй.

4.3 Үнэлгээний хороонд ажиллах гишүүдэд хурлын товыг нарийн бичгээр дамжуулан мэдэгдэх ба хуралд заавал оролцохыг шаардах эрхтэй.

4.4 Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг ажиллах орчин, техник хэрэгслээр хангах үүрэгтэй.

4.5 Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаас худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажиллахаар ирүүлсэн гишүүн нь үнэлгээний хороонд ажиллах явцдаа ашиг сонирхлын зөрчил бүхий аливаа үйлдэл, эс үйлдэл гаргасан тохиолдолд үнэлгээний хорооноос хасаж, үнэлгээний хорооны үйл ажиллагааны зардал, учирсан хохирлыг шаардах эрхтэй.

4.6 Энэ гэрээний гол нөхцөл, эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

4.7 Энэ гэрээний 5.3-т заасан шаардлагыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй, үнэлгээний хорооны хуралд 2-оос дээш удаа оролцоогүй бол гишүүнээс чөлөөлөх эрхтэй.

4.8 Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах төрийн бус байгууллагын гишүүнд үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах талаар заавар зөвлөгөө өгөх, хууль сануулах, хууль мөрдөж ажиллахыг шаардах эрхтэй.

4.9 Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж буй мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын гишүүн нь тендер шалгаруулалтын үйл ажиллагаа, үнэлгээнд хууль бус арга хэрэгслээр нөлөөлсөн, төсөл, арга хэмжээний талаарх хаалттай аливаа мэдээ, мэдээллийг задруулсан бол холбогдох байгууллагад мэдэгдэх, үнэлгээний хорооноос хасах эрхтэй.

4.10 Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллаж, үнэлгээний хорооны нийт хуралдаанд бүрэн оролцсон гишүүдэд урамшуулал олгох үүрэгтэй.

4.11 Үнэлгээний хорооны үйл ажиллагааг санаатайгаар будлиантуулсан, хугацаа алдуулсан бол төрийн байгууллагад учирсан хохирлыг мэргэжлийн холбоод, төрийн байгууллагаар төлүүлэх, эсхүл түүгээр уламжлан буруутай этгээдээр төлүүлэх эрхтэй.

Тав. Төрийн бус байгууллагын эрх, үүрэг

5.1 Төрийн бус байгууллага нь үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төлөөлөл оруулахдаа дараах материалыг төрийн байгууллагад бичгээр ирүүлэх үүрэгтэй;

5.1.1 Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төлөөлөл оруулах тухай албан бичиг;

5.1.2 Төрийн бус байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

5.1.3 Төрийн бус байгууллагын танилцуулга;

5.1.4 Хавсралтад заасны дагуу Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оруулах төлөөллийн анкет;

5.1.5 Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох АЗ гэрчилгээний хуулбар;

5.2 Үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон гишүүдийг төрийн байгууллагаас товлосон цаг, газарт үнэлгээний хорооны хуралд оролцох үүрэгтэй.

5.3 Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах төрийн бус байгууллагын гишүүдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авилгын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн хүрээнд ажиллах, үүссэн асуудлыг өөрөө бие даан хариуцах талаар сургалт, зөвлөгөө, чиглэл олгох үүрэгтэй.

5.4 Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах гишүүдийг хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг бөглөж, ашиг, сонирхлын зөрчлөөс ангид байх талаар шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй.

5.5 Энэ гэрээгээр тохиролцсон гол нөхцөл, эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон төрийн бус байгууллагын төлөөлөл үнэлгээний хорооны хуралд заавал оролцуулах үүрэгтэй.

5.6 Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах төрийн бус байгууллагын гишүүн нь худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны үйл ажиллагаанд салбар харгалзахгүй гишүүнээр ажиллах үүрэгтэй.

5.7 Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах төрийн бус байгууллагын төлөөлөл нь ашиг сонирхлын зөрчил байгаа эсэх талаарх мэдэгдлийг үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон өдрөөр илэрхийлэх бөгөөд ашиг сонирхол үүссэн бол энэ тухай мэдэгдлийг тендер шалгаруулалтын аль ч үе шатанд гаргах үүрэгтэй.

5.8 Худалдан авах ажиллагаатай холбоотой аливаа мэдээ, мэдээлэл, нууцыг задруулснаас учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

Зургаа. Гэрээний хариуцлага

6.1 Төрийн байгууллага нь өөрийн болон харьяа салбар, хүрээний байгууллагуудын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

6.2 Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаас санал болгосон үнэлгээний хорооны гишүүн нь худалдан авах ажиллагааны чиглэлээр өөрийн мэдлэг, мэдээллийг байнга шинэчилж, худалдан авах ажиллагааг шуурхай, ил тод, шударга явуулах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

6.3 Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллаж буй мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын гишүүн нь тендер шалгаруулалтын үйл ажиллагаа, үнэлгээнд хууль бус арга хэрэгслээр нөлөөлсөн, төсөл, арга хэмжээний талаарх хаалттай аливаа мэдээ, мэдээллийг задруулсан бол учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

6.4 Үнэлгээний хорооны хуралдаанд 2-оос дээш удаа оролцоогүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах мэдлэг, чадвар хангалтгүй этгээдэд урамшуулал олгохгүй.

Долоо.Бусад зүйл

7.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүй.

7.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон түүнд нийцүүлэн гарсан хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

7.3 Энэхүү гэрээг талууд 4 эх хувь үйлдэх бөгөөд тус бүр 2 эх хувийг хадгална. Эх тус бүр адил хүчинтэй.

7.4 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд талуудын итгэмжлэгдсэн төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.5 Энэхүү гэрээ нь Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд аливаа гарсан маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

Гэрээ байгуулсан:

Захиалагчийг төлөөлж:	Гүйцэтгэгчийг төлөөлж
Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Эрдэнэсүрэн	
Байршил, утас: Нутгийн удирдлагын ордон 5 дугаар давхар, 501тоот	Байршил, утас:
Хаяг: Нутгийн удирдлагын ордон 5 дугаар давхар, 501тоот	Хаяг:
Утас: 70322307, 99146421	Утас:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНД АЖИЛЛАХ САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООД,
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ДООРХ ХҮСНЭГТИЙН ДАГУУ
МЭДЭЭЛЛЭЭ ИРҮҮЛНЭ ҮҮ.

1. Ерөнхий мэдээлэл	
1.1	Эцэг/Эхийн нэр:
1.2	Нэр:
1.3	Регистрийн дугаар:
1.4	Хүйс:
1.5	Цахим хаяг:
1.6	Холбоо барих утас:
1.7	Хувийн харилцах данс /банкны нэр/:
2. Гадаад хэлний мэдлэг	
2.1	Гадаад хэл:
2.2	Чадвар: /Онц сайн, сайн, дунд, анхан шат/
3. Харьяалагдаж буй төрийн бус байгууллагын нэр :	
3.1	Салбар:
3.2	Албан тушаал:
3.3	Байгууллагын хаяг:
4. Давхар ажил эрхлэлтийн байдал	
4.1	Ажиллаж буй байгууллагын нэр:
4.2	Албан тушаал:
5. Боловсрол	
5.1	Зэрэг: /Бакалавр, Магистр, Доктор г.м/
5.2	Мэргэжил:
5.3	Мэргэжлээрээ ажилласан жил:
6. Сертификатын бүртгэл	
6.1	Сертификатын төрөл: /А3, Б5/
6.2	Сертификатын дугаар:
6.3	Хүчинтэй хугацаа: /Эхлэх , дуусах огноо/
6.4	Сертификат авсан огноо: